

МӨСТӨЛТ

Агаарын хөлгийн нислэгийн үед түүний их бие, далавч, сүүлний мөлгөр хэсгүүд болон хэмжигч багажуудын мэдрэгч (датчик) дээр мөс үүсэх үзэгдлийг мөстөлт гэнэ.

Мөстөлт үүсэх цаг уурын нөхцөл:

Агаарын хэм 0°C -ээс доош орсон үед мөстөлт ажиглагдах магадлал хамгийн их болно.

- ◆ Бөөн, Борооны давхраат үүлэнд
- ◆ Хүйтэн фронтын бүсэд
- ◆ Уул ба дов толгодын дээр
- ◆ Зарим дулаан фронтын өмнө

Шилжилтийн улиралд -18°C хүртэл хүйтэн температуртай, шингэн дусал бүхий борооны давхраат (Ns), өндрийн давхраат (As) болон давхраат бөөн (Sc) үүлэнд мөстөлт үүсэх магадлал хамгийн их буюу (90 хүртэл %) байдаг.

- Мөстөлтийн эрчим нь нислэгийн өндрийн агаарын температур, үүлний усаг, тунадас орж байгаа эсэх, мөстөлтийн бүсэд онгоц байх хугацаа, онгоцны хурд ба төрөл зэргээс хамаардаг. Хамгийн аюултай мөстөлт нь удаан шилжилттэй хүйтэн фронт, дулаан фронтын өмнөх хүйтэн агаарын цул дотор хэт хөрсөн усан дусал бүхий бороотой үүлэнд нислэг үйлдэхэд тохиолддог байна.

Мөстөлтийн эрчим

- **Сул /Ψ/:** Нислэг ийм орчинд 1 цагаас илүү хугацаанд явагдвал асуудал үүсч магадгүй.
- **Дунд /Ψ/:** Мөстөлтийн эсрэг арга хэмжээ авах боломжтой.
- **Хүчтэй /Ψ/:** Мөстөлтийн эсрэг арга хэмжээ авах боломжгүй ба нислэгт шууд нөлөөлдөг учраас маш аюултай.

Онгоцны гадарга дээрх нөлөөллүүд:

- ☞ Аэродинамик нөлөө буюу өндөр алдах
- ☞ Их биеийн жин өсөх
- ☞ Хөдөлгүүр зогсох
- ☞ Онгоцны дугуй буухгүй болох
- ☞ Холбооны хэрэгсэлд нөлөөлнө
- ☞ Харах талбайг багасгана
- ☞ Онгоцны доргилт илүү их болно
- ☞ Түлшний зарцуулалт ихэсгэх

→ **Нисдэг тэрэгний нислэгийн үед түүний сэнс мөстөх нь хамгийн аюултай бөгөөд ихэвчлэн сэнсний алганы уг болон дунд хэсэг мөстдөг байна.**

- ☞ **Хөдөлгүүрийн мөстөлт:** Агаарын температур 0-5 градусд хөдөлгүүрийн мөстөлт ажиглагддаг.
- ☞ **Онгоцны гадаргын мөстөлт:** Онгоцны гадаргын температур хөрч хөлдөх буюу онгоцны гадарга дээр хэт хөрсөн усан дуслууд ирж наалдахад үүснэ.
 - Цантах /Маш жижиг хэт хөрсөн усан дуслууд, маш бага температур, түргэн хөлдөнө/
 - Мөстөх /Том хэмжээтэй хэт хөрсөн усан дуслууд, зөвхөн 0 градусаас бага температурт, удаан хөлдөнө /



Мөстөлтөөс хэрхэн сэргийлэх талаар

- Мөстөлттэй тэмцэх шууд аргын нэг нь 0°C -аас хүйтэн буюу хасах температуртай чийглэг агаар болон үүлэнд орохын өмнө мөстөлт эсэргүүцэх системээ заавал залгаж, түүнийг нислэгийн ашиглалтын зааврыг баримтлан ажиллуулна. Энэ нь мөстөлт эсэргүүцэх системийн төрөл (механик, физик-химийн, цахилгаан-дулааны, халуун хийн), мөстөлттэй бүсэд нислэг үргэлжлэх хугацаанаас хамаардаг учир тийм ч найдвартай арга биш юм.
- Мөстөлттэй тэмцэх аргын нөгөө нь нислэгийн цаг уурын байгууллагаас гаргасан мэдээ материалыг үндэслэн янз бүрийн өндөр дэх цаг уурын нөхцлүүд (агаарын температур, чийгшил ба үүлний орон зайн тархалт, үүлний фазын төлөв байдал)-ийг нарийвчлан судалж мөстөлттэй бүсээс зайлсхийх, тойрон гаргах явдал байдаг. Энэ нь бага мөстөх магадлалтай маршрут болон эшелоныг сонгон нисэхэд үндэслэгддэг учраас хамгийн сайн аргад тооцогддог.

Эцэст нь анхаарахад:

- ☞ Хавар, намрын шилжилтийн улиралд мөстөлтөнд өртөх магадлал илүү их байдаг.
- ☞ Дулааны улиралд борооны бөөн үүл, хүйтний улиралд давхраат хэлбэрийн үүлэнд мөстөлт үүсэх магадлал их байдаг.
- ☞ Автомат жолоодлого нь мөстөлтөөс хамгаалдаг ч бүрэн гүйцэд хамгаалж чаддаггүй
- ☞ Далайн эргийн үүл нь цөөн тооны том дусалтай байдаг ба давхраат хэлбэрийн үүлэн дэх услаг нь босоо хөгжлийн үүлэн дэхийг бодвол 10 дахин бага байдаг
- ☞ Мөстөлтийн тархалт нь ихэвчлэн 60м-ээс 90 км-т (2-3000ft), цөөн тохиолдолд 150км (5000ft) ба түүнээс их зайд тархаж байрладаг байна.